

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Номундалай сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/051/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор хот

2026

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер М.Алтантуяа
Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитор Д.Оюун-Эрдэнэ
Утас: 88916603 Цахим хаяг: oyun-erdenede@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН НОМУНДАЛАЙ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ц.БУЯНТОГТОХ ТАНАА

2026.02.25 № 2/103
танай _____-ны № _____-т

Г **Өөрчлөлтгүй дүгнэлт** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Номундалай сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Тайлант онд аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 1,315,423.2 мянган төгрөгийн сургуулийн гадна спорт талбай, 96,839.0 мянган төгрөгийн автомашины зогсоол талбай хийж ашиглалтад хүлээн авсан байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	888,617,198.11	787,632,898.19
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	355,795,029.16	124,412,162.11
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	355,795,029.16	124,412,162.11
3121	Төгрөг	355,795,029.16	124,412,162.11
31211	Төрийн сангийн харилцах	355,795,029.16	124,412,162.11
33	АВЛАГА	1,636,218.98	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,636,218.98	-
35	БАРАА МАТЕРИАЛ	531,185,949.97	663,220,736.08
351	Түүхий эд материал	2,720,200.00	3,135,200.00
35130	Эм боох материал	2,720,200.00	3,135,200.00
354	Хангамжийн материал	528,465,749.97	660,085,536.08
35410	Бичиг хэргийн материал	7,057,500.00	4,576,500.00
35420	Аж ахуйн материал	8,622,900.00	5,153,250.00
35450	Барилгын засварын материал	5,202,540.21	-
35460	Хүнсний материал	611,550.00	110,000.00
35470	Бусад хангамжийн материал	506,971,259.76	650,245,786.08
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10,366,247,576.73	11,424,388,984.30
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,366,247,576.73	11,424,388,984.30
392	Биет хөрөнгө	9,408,482,576.61	10,506,718,984.14
39201	Барилга, байгууламж, орон сууц	9,508,961,367.00	10,921,223,639.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(884,110,448.81)	(1,086,305,793.65)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,118,115,263.07	1,008,632,351.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	(564,265,108.79)	(549,542,137.54)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	459,681,306.58	365,327,820.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	(269,060,410.64)	(191,777,503.55)
39217	Ном	39,160,608.20	39,160,608.20
393	Биет бус хөрөнгө	957,765,000.12	917,670,000.16
39301	Програм хангамж	13,715,000.00	13,715,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(10,574,999.88)	(12,144,999.84)
39303	Бусад биет бус хөрөнгө	954,625,000.00	916,100,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	11,254,864,774.84	12,212,021,882.49
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	63,747,748.00	109,621,025.47
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	63,747,748.00	109,621,025.47
413	Өглөг	63,747,748.00	109,621,025.47
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	27,832,793.47
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	28,665,109.00
4136	Бусад өглөг	63,747,748.00	53,123,123.00
41361	Байгууллагад төлөх өглөг	63,747,748.00	53,123,123.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	11,191,117,026.84	12,102,400,857.02
51	Засгийн газрын хувь оролцоо	11,191,117,026.84	12,102,400,857.02
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,483,997,027.68	2,483,997,027.68
51101	Өмч: - төрийн	2,483,997,027.68	2,483,997,027.68
512	Хуримтлагдсан үр дүн	7,703,666,187.60	8,614,950,017.78
51210	Өмнөх үеийн үр дүн	7,703,666,187.60	7,703,666,187.60
51220	Тайлант үеийн үр дүн	-	911,283,830.18
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,003,453,811.56	1,003,453,811.56
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	11,254,864,774.84	12,212,021,882.49

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	8,550,538,780.00	9,157,239,329.22
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,324,864,280.00	1,664,870,729.22
120	Нийтлэг татварын бус орлого	1,324,864,280.00	1,664,870,729.22
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,324,864,280.00	1,664,870,729.22
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	128,738,500.00	107,667,160.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,526,900.00	-
120009	Бусад орлого	954,625,000.00	9,257,100.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /ҮХ/	183,209,497.00	1,427,857,762.90
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /БМ/	48,764,383.00	120,088,706.32
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,225,674,500.00	7,492,368,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,264,200,800.00	6,484,370,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,264,200,800.00	6,484,370,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	961,473,700.00	1,007,998,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	961,473,700.00	1,007,998,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,426,881,689.09	8,207,430,499.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,426,881,689.09	8,207,430,499.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,188,203,536.43	7,873,525,153.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,873,139,303.71	5,398,789,640.85
210101	Үндсэн цалин	2,978,566,711.71	3,160,410,277.48
210102	Нэмэгдэл	1,643,263,705.00	1,833,616,676.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	143,290,691.00
210104	Урамшуулал	251,308,887.00	261,471,995.98
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	615,125,000.00	682,966,000.00
210201	Тэтгэврийн даатгал	418,285,000.00	464,417,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	49,210,000.00	54,637,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	24,605,000.00	27,318,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	24,605,000.00	27,318,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	98,420,000.00	109,274,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	922,161,499.34	1,011,639,843.21
210301	Гэрэл, цахилгаан	50,711,446.34	61,089,377.21
210302	Түлш, халаалт	782,622,960.00	824,948,770.00
210303	Цэвэр, бохир ус	88,827,093.00	125,601,696.00
2104	Хангамж, бараа материалын зардал	139,381,010.14	114,092,179.21
210401	Бичиг хэрэг	93,689,000.00	65,117,120.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	123,043.14	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	45,568,967.00	48,975,059.21
2105	Нормативт зардал	58,500.00	674,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	58,500.00	674,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	59,167,700.00	56,186,445.00

Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Номундалай сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210604	Урсгал засвар	59,167,700.00	56,186,445.00
2107	Томилолт, зочны зардал	524,200.00	600,000.00
210702	Дотоод албан томилолт	524,200.00	600,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,372,528.72	90,737,109.11
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	9,257,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	60,372,528.72	81,480,009.11
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	518,273,794.52	517,839,335.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	115,642,516.00	91,756,980.54
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,350,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	401,281,278.52	426,082,355.33
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	238,678,152.66	333,905,345.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	238,678,152.00	328,881,980.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	238,678,152.00	328,881,980.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.66	5,023,365.79
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.66	5,023,365.79
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,123,657,090.91</u>	<u>949,808,830.18</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	942,552,921.43	38,525,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	942,552,921.43	38,525,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(942,552,921.43)	(38,525,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>181,104,169.48</u>	<u>911,283,830.18</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>7,363,939,900.00</u>	<u>7,609,292,860.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	138,265,400.00	116,924,260.00
120	Нийтлэг татварын бус орлого	138,265,400.00	116,924,260.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	138,265,400.00	107,667,160.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	128,738,500.00	107,667,160.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,526,900.00	00.00
120009	Бусад орлого	00.00	9,257,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,225,674,500.00	7,492,368,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,264,200,800.00	6,484,370,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,264,200,800.00	6,484,370,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	961,473,700.00	1,007,998,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	961,473,700.00	1,007,998,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>7,164,749,917.75</u>	<u>7,745,784,727.05</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,164,749,917.75	7,745,784,727.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,926,055,378.89	7,412,380,931.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,875,138,524.69	5,369,320,628.40
210101	Үндсэн цалин	2,980,565,932.69	3,132,577,484.01

Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Номундалай сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210102	Нэмэгдэл	1,643,263,705.00	1,833,656,676.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	143,290,691.00
210104	Урамшуулал	251,308,887.00	259,795,777.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	615,125,000.00	682,966,000.00
210201	Тэтгэврийн даатгал	418,285,000.00	464,417,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	49,210,000.00	54,637,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	24,605,000.00	27,318,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	24,605,000.00	27,318,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	98,420,000.00	109,274,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	920,111,499.34	982,974,734.21
210301	Гэрэл, цахилгаан	50,782,154.34	61,089,377.21
210302	Түлш, халаалт	780,572,960.00	796,283,661.00
210303	Цэвэр, бохир ус	88,756,385.00	125,601,696.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,362,200.00	20,000,000.00
210604	Урсгал засвар	41,362,200.00	20,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	139,244,528.72	116,577,734.11
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	9,257,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	139,244,528.72	107,320,634.11
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	335,073,626.14	240,541,834.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	272,034,826.14	204,734,894.54
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	63,038,800.00	35,806,940.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	238,694,538.86	333,403,795.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	238,694,538.20	328,380,430.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	238,694,538.20	328,380,430.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.66	5,023,365.79
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.66	5,023,365.79
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>199,189,982.25</u>	<u>(136,491,867.05)</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	118,647,452.00	94,891,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	118,647,452.00	94,891,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	118,647,452.00	94,891,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	118,647,452.00	94,891,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(118,647,452.00)</u>	<u>(94,891,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	80,542,530.25	(231,382,867.05)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	275,252,498.91	355,795,029.16
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	355,795,029.16	124,412,162.11

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	/төгрөгөөр/ Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	2,483,997,027.68	1,153,473,211.56	7,360,848,618.12	00.00	10,998,318,857.36
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	150,019,400.00	00.00	150,019,400.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,483,997,027.68	1,153,473,211.56	7,510,868,018.12	00.00	11,148,338,257.36
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	181,104,169.48	00.00	181,104,169.48
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,483,997,027.68	1,003,453,811.56	7,703,666,187.60	00.00	11,191,117,026.84
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	2,483,997,027.68	1,003,453,811.56	7,703,666,187.60	00.00	11,191,117,026.84
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,483,997,027.68	1,003,453,811.56	7,703,666,187.60	00.00	11,191,117,026.84
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	911,283,830.18	00.00	911,283,830.18
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,483,997,027.68	1,003,453,811.56	8,614,950,017.78	00.00	12,102,400,857.02

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /улсын төсөв/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	/төгрөгөөр/ Хувь
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,953,786,300.00	6,601,294,760.00	352,491,540.00	94.9
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6,499,468,100.00	6,484,370,500.00	15,097,600.00	99.8
Улсын төсвөөс санхүүжих	6,499,468,100.00	6,484,370,500.00	15,097,600.00	99.8
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	454,318,200.00	116,924,260.00	337,393,940.00	25.7
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	149,257,100.00	107,667,160.00	41,589,940.00	72.1
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	305,061,100.00		305,061,100.00	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		9,257,100.00	(9,257,100.00)	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,953,786,300.00	6,832,677,627.05	121,108,672.95	98.3
УРСГАЛ ЗАРДАЛ	6,953,786,300.00	6,832,677,627.05	121,108,672.95	98.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,603,382,200.00	6,504,297,197.05	99,085,002.95	98.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,458,879,900.00	5,369,320,628.40	89,559,271.60	98.4
Үндсэн цалин	3,402,966,300.00	3,132,577,484.01	270,388,815.99	92.1
Нэмэгдэл	1,906,567,300.00	1,833,656,676.39	72,910,623.61	96.2
Унаа хоолны хөнгөлөлт		-	143,290,691.00	(143,290,691.00)
Урамшуулал	149,346,300.00	259,795,777.00	(110,449,477.00)	174.0

Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Номундалай сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	683,391,100.00	682,966,000.00	425,100.00	99.9
Тэтгэврийн даатгал	464,706,000.00	464,417,100.00	288,900.00	99.9
Тэтгэмжийн даатгал	54,671,400.00	54,637,200.00	34,200.00	99.9
ҮОМШӨ-ний даатгал	27,335,600.00	27,318,500.00	17,100.00	99.9
Ажилгүйдлийн даатгал	27,335,600.00	27,318,500.00	17,100.00	99.9
Эрүүл мэндийн даатгал	109,342,500.00	109,274,700.00	67,800.00	99.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	124,988,800.00	116,577,734.11	8,411,065.89	93.3
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,257,100.00	9,257,100.00	-	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	115,731,700.00	107,320,634.11	8,411,065.89	92.7
Бараа үйлчилгээний бусад зардал	336,122,400.00	335,432,834.54	689,565.46	99.8
Бараа үйлчилгээний бусад зардал	300,315,300.00	299,625,894.54	689,405.46	99.8
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	35,807,100.00	35,806,940.00	160.00	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	350,404,100.00	328,380,430.00	22,023,670.00	93.7
Бусад урсгал шилжүүлэг	350,404,100.00	328,380,430.00	22,023,670.00	93.7
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	350,404,100.00	328,380,430.00	22,023,670.00	93.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	355,795,029.16		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	124,412,162.11		

Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /орон нутгийн төсөв/

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,007,998,100.00	1,002,974,734.21	5,023,365.79	99.5
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,007,998,100.00	1,002,974,734.21	5,023,365.79	99.5
Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,007,998,100.00	1,002,974,734.21	5,023,365.79	99.5
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,007,998,100.00	1,002,974,734.21	5,023,365.79	99.5
УРСГАЛ ЗАРДАЛ	1,007,998,100.00	1,002,974,734.21	5,023,365.79	99.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,007,998,100.00	1,002,974,734.21	5,023,365.79	99.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	987,998,100.00	982,974,734.21	5,023,365.79	99.5
Гэрэл, цахилгаан	66,112,700.00	61,089,377.21	5,023,322.79	92.4
Түлш, халаалт	796,283,700.00	796,283,661.00	39.00	100.0
Цэвэр, бохир ус	125,601,700.00	125,601,696.00	4.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	20,000,000.00	20,000,000.00	-	100.0
Урсгал засвар	20,000,000.00	20,000,000.00	-	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тайлант онд тус сургууль нь "Амжилтаа ахиулъя" эрхэм зорилгын доор дараах зорилтуудыг хэрэгжүүлж ажилласан байна.

1. 2025-2026 оны хичээлийн жилд шинээр батлагдсан хууль, журам, тогтоол зэргийг суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, багш, ажилтан, иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, тэдний оролцоотой хэрэгжүүлэх.

2. Хамран сургах тойргийн сурагчдыг бүрэн хамруулж тэдний хөгжил, төлөвшлийг дэмжин сурлагын амжилтад ахиц гаргах.

3. Цагийн алдагдалгүй ажиллаж, ээлжит хичээлийг чанартай зааж, хичээлийн бэлтгэлийг тогтмол хийж хэвших, хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдал, явцын үнэлгээнд суурилан сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлэх.

4. Төрөлжсөн хичээлийн олимпиад, аймаг улс, олон улсын чанартай уралдаан тэмцээний амжилтыг ахиулах.

5. Суралцагчийн математик, англи хэлний сургалтыг дэмжих цахим технологи (сургалтын платформ)-д суурилсан нэмэлт хөтөлбөрийг бага, суурь боловсролын 2-8 дугаар ангид үр дүнтэй хэрэгжүүлэх, орчин бүрдүүлэх.

6. Багш, суралцагч цахим ба AI технологийн тусламжтай бие даан суралцах, ирээдүйн иргэнд шаардагдах чадамж эзэмших, хиймэл оюун ухааныг ёс зүйтэй, бүтээлчээр ашиглах.

7. Багшийн зохицуулах цагаар сурагчдын тулгамдсан асуудлыг илрүүлж, хэрэгцээнд тулгуурлан, хөгжил, төлөвшил, хүмүүжилд эерэг өөрчлөлт гаргах нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах.

8. Мэргэжлийн багш нарын бүлгийн үйл ажиллагаагаар дамжуулан багш ажлын байрандаа хөгжих олон талт үйл ажиллагааг зохион байгуулж, сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх.

9. Дунд, ахлах ангийн суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлээ зөв сонгоход дэмжлэг үзүүлэх, "Практикт суурилсан ажил мэргэжлийн чиг баримтаа" төслийг хэрэгжүүлнэ.

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу сургуулийн захирлын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дугаар тушаалаар сургуулийн зөвлөл, Захирлын дэргэдэх зөвлөл, Сургалтын алба, Хүүхэд хөгжлийн алба, Захиргаа аж ахуй гэсэн бүтэц зохион байгуулалттай 186 орон тоотой ажиллахаас, 164 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Тайлант хугацаанд бага ангийн 22 бүлэгт 948 сурагч, дунд ангийн 36 бүлэгт 1406 сурагч, ахлах ангийн 22 бүлэгт 850 сурагч, дүйцсэн хөтөлбөрт 25 сурагч, нийт 81 бүлэгтэйгээр 3226 сурагчдыг хичээл сургалтын үйл ажиллагаанд хамруулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Монгол улсын засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 238 дугаар тогтоолоор цалин хөлсний хэмжээнд өөрчлөлт орсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүргийг Боловсролын ерөнхий газрын дотоод аудитын нэгж хэрэгжүүлдэг ба тайлант онд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Номундалай сургууль нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Номундалай сургууль нь 2025 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын тушаалаар батлагдсан заавар журмууд, УСНББОУС-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 957,157.1 мянган төгрөг буюу 8.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	888,617.2	787,632.9	(100,984.3)
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	355,795.0	124,412.2	(231,382.9)
Авлага	1,636.2	-	(1,636.2)
Бараа материал	531,186.0	663,220.7	132,034.8
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10,366,247.6	11,424,389.0	1,058,141.4
Үндсэн хөрөнгө	12,094,258.5	13,264,159.4	1,169,900.9
Хуримтлагдсан элэгдэл	(1,728,011.0)	(1,839,770.4)	(111,759.5)
Нийт хөрөнгө	11,254,864.8	12,212,021.9	957,157.1
Өр төлбөр	63,747.8	109,621.0	45,873.3
Засгийн газрын хувь оролцоо	11,191,117.0	12,102,400.9	911,283.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/ өмчийн дүн	11,254,864.8	12,212,021.9	957,157.1

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Номундалай сургуулийн 2025 оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо данснуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 124,412.2 мянган төгрөг болж өмнөх оноос 231,382.9 мянган төгрөгөөр буурсан нь улсын төсвөөс 6,484,370.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 107,667.2 мянган төгрөг, сурах бичгийн түрээс 9,257.1 мянган төгрөг төвлөрч үйл ажиллагааны зардалд 6,832,677.6 мянган төгрөг зарцуулсантай холбоотой байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 497,251.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 120,088.7 мянган төгрөгийн бараа үнэ төлбөргүй орлого авч, нийт 485,305.0 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсантай холбоотойгоор бараа материалын үлдэгдэл 132,034.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн 1,315,423.2 мянган төгрөгийн сургуулийн гадна спорт талбай, 96,839.0 мянган төгрөгийн автомашины зогсоол талбай, НҮБ-ийн хүүхдийг ивээх сангаас 7,729.0 мянган төгрөгийн машин, компьютер, таблет, БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 5,800.0 мянган төгрөгийн аяга таваг угаач, ариутгагч, төсвийн хөрөнгөөр 94,891.0 мянган төгрөгийн тавилга, машин тоног төхөөрөмж худалдан авч, аймгийн ИТХ-ын даргын 2024 оны "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 98 дугаар захирамжаар 38,525.0 мянган төгрөгийн газрыг аймгийн ИТХ-д шилжүүлж, аймгийн ИТХ-ын хуралдааны 2025 оны "Хөрөнгө акталж, данснаас хасах тухай" 7/42 дугаар тогтоолоор 314,322.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгасан байна.

Өглөгийн үлдэгдэл 109,621.0 мянган төгрөг. Үүнээс:

- 53,123.1 мянган төгрөг нь цахим ангийн тоног төхөөрөмж зээлээр худалдан авсантай холбоотой өрийн үлдэгдэл бөгөөд тайлант онд гэрээнд заасан төлбөр

болох 10,624.6 мянган төгрөгийн төлсөн байна.

- 28,665.1 мянган төгрөг нь 2025 оны 09 дүгээр сарын түлш халаалтын зардлын өглөг бөгөөд Баянхонгор аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс өгсөн чиглэлийн дагуу өглөгөөр тайлагнасан байна.
- 27,832.8 мянган төгрөг нь ажилчидтай холбоотой ХХОАТ-ын өр бөгөөд санхүүжилт нь сарын эцэст гүйлгээ хаагдах үед орж ирсэнтэй холбоотойгоор үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 12,102,400.9 мянган төгрөг болж 911,283.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Тус байгууллагын программ хангамжтай холбоотой мэдээлэл:

№	Программын талаарх ерөнхий мэдээлэл					Санхүүгийн тайлан дахь бүртгэл /төгрөг/	
	Программ хангамжийн нэр	Одоо ашиглаж байгаа эсэх /тийм, үгүй/	Программын зориулалт	Ашиглаж эхэлсэн огноо	Ашиглаж буй нэгж	Санхүүгийн тайланд бүртгэлтэй эсэх /тийм, үгүй/	Санхүүгийн тайлан дахь бүртгэлийн дүн /төгрөгөөр
1	Санхүүгийн программ /Acolous/	тийм	Санхүүгийн тайлан гаргах	2009.04.10	Нягтлан бодогч	үгүй	-
2	Анги дэвших шалгалтын даалгаврын сан	үгүй	Архивын программ	2019.04.22	Сургалтын алба	тийм	90,000.0
3	NoDa апплэйкшн	тийм	1.2 р ангийн монгол хэлний хичээлийг бататгах зорилготой апп	2021.12.28	Сургалтын алба	тийм	7,850,000 .0
4	Программ /Хичээлийн/	үгүй	Программ / Хичээлийн /	2010.12.31	Сургалтын алба	тийм	300,000.0
5	Няравын программ	тийм	Санхүүгийн тайлан гаргах	2015.03.25	Нярав	тийм	275,000.0
6	ЭЕШ тест унших программ-2020	тийм	ЭЕШ тест унших программ	2020.02.29	Сургалтын алба	тийм	5,200,000.0
ДҮН							13,715,000.0

Тайлант онд Acolous санхүүгийн программтай холбоотойгоор 737.0 мянган төгрөг урсгал зардлын төсвөөс зарцуулагдсан байна.

Программын хугацаа дууссан учир 2 программ ашиглалтгүй байна.

Тус байгууллага нь тайлант онд сургалтын үйл ажиллагаанд ашиглаж буй математик /эдүтэн/ хичээлийн программын үйлчилгээний төлбөрт 13,699.6 мянган төгрөг, англи хэлний /pearson/ хичээлийн программын үйлчилгээний төлбөрт 40,496.5 мянган төгрөг, боловсролын нэгдсэн системийн esis.edu.mn/hr/ программын төлбөрт 25,360.0 төгрөгийг төлсөн байна.

Газар эзэмших, ашиглах эрхийн байдал

Тус байгууллагад 36,644 м2 талбай бүхий эзэмших эрхтэй 2 газрыг 2021, 2022 онуудад 15 жилийн хугацаатай эзэмшүүлж, гэрчилгээг олгосон байна. Газартай холбоотой бүртгэл тайлангийн мэдээлэл нь газар эзэмших эрхийн гэрчилгээ болон цахим санд (egazar.gov.mn) дахь мэдээлэлтэй тохирч байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 8,128,625.3 мянган төгрөгөөр тооцон зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төслийн саналаас зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зардлыг 1,987,696.1 мянган төгрөгөөр бууруулж 6,140,929.2 мянган төгрөгөөр баталж өгсөн байна.

Төсвийн төслийг 2025 оны 12 дугаар сард тодотгон 812,857.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 6,953,786.3 мянган төгрөгөөр баталсан байна. Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 6,499,468.1 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 149,257.1 мянга, урьд оны үлдэгдлээс 305,061.1 мянган төгрөгөөр тодотгож, ажилчдын цалин хөлс, ажил олгогчийн төлөх ЭМНДШ болон бараа үйлчилгээний бусад зардлыг нэмэгдүүлж өгсөн байна.

Орон нутгийн төсвөөс 1,093,324.2 мянган төгрөгөөр тогтмол зардал болон урсгал засварын зардлыг санхүүжүүлэхээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 6,840,165.5 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 107,667.2 мянган төгрөг, сурах бичгийн түрээсийн орлого 9,257.1 мянган төгрөг, нийт 6,832,677.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 6,823,420.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Орон нутгийн төсвөөс 1,007,998.1 мянган төгрөгийн санхүүжилт авч 1,002,974.7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 5,023.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/			
	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт (хувь)
71802	Ерөнхий боловсрол				
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	10,085.4	10,085.4	0.0	100.0
80233	Хүүхэд хамгаалал	10,373.2	9,722.0	651.2	93.7

Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Номундалай сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

80312	Сургалт семинар	5,554.6	5,554.6	0.0	100.0
81605	Эрүүл мэндийг дэмжих	10,632.1	10,632.0	0.1	100.0
81801	Үдийн цай хөтөлбөр	350,404.1	328,380.4	22,023.7	93.7
81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	99,555.1	99,555.1	0.0	100.0
81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	19,565.7	19,527.7	38.0	99.8
81827	Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	26,554.6	18,772.6	7,829.3	70.6
81834	Боловсролын стандарт, сургалтын	6,048,682.2	5,994,018.5	62,865.7	99.0
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	154,803.7	154,803.7	0.0	100.0
81844	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	158,226.1	125,246.6	32,979.5	79.2
81848	Сурах бичгийн түрээс	9,257.1	9,257.1	0.0	100.0
81875	Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	50,092.4	47,121.9	2,970.5	94.1
Дүн		6,953,786.3	6,832,677.6	121,108.7	98.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Үндсэн үйл ажиллагааны орлого

Тус сургууль нь тайлант онд үндсэн үйл ажиллагаанаас 140,000.0 мянган төгрөгийн орлого олох төлөвлөгөөтэйгөөс гүйцэтгэлээр 107,667.2 мянган төгрөгийн орлого олж орлогын төлөвлөгөөг 76.9 хувьтай биелүүлсэн байна. Тус орлогыг үндсэн дансандаа төвлөрүүлж, гүнзгийрүүлсэн сургалт явуулах журам, сонгон, секц, дугуйлан хичээллүүлэх журмын дагуу, захиран зарцуулсан байна.

Тайлант онд математик, англи хэлний гүнзгийрүүлсэн сургалт хичээллүүлж 64,177.0 мянган төгрөг, спортын төрлүүд, дуу, бүжгийн секц дугуйлан хичээллүүлж 34,484.0 мянган төгрөг, бусад орлого 9,006.2 мянган төгрөгийн орлого олж, орлогын 70 хувийг багш нар болон үйлчлэгчийн цалин хөлсөнд, 20 хувийг сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх, орчин нөхцөлийг сайжруулахад, үлдсэн 10 хувийг хичээллэх байр, танхимтай холбоотой зардал, уралдаан тэмцээнд оролцох зардал, хуримтлалд зарцуулсан байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас дараах судалгааг авсан. Үүнд:

1. Байгууллагын орон тооны цомхотгол: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын 2018 оны А/024/11 дугаар хамтарсан тушаалаар “Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг нормативыг тогтоож өгсөн байна. Тус байгууллага нь захирлын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дугаар тушаалаар сургуулийн зөвлөл, Захирлын дэргэдэх зөвлөл, Сургалтын алба, Хүүхэд хөгжлийн алба, Захиргаа аж ахуй гэсэн бүтэц зохион байгуулалттай 186 орон тоотой ажиллахаас, 164 орон тоотой ажилласан.

2025 онд цалингийн зардалд 5,458,879.9 мянган төгрөг төлөвлөгдөж, гүйцэтгэлээр 5,369,320.6 мянган төгрөг зарцуулагдсан байна. Тайлант онд орон тооны цомхотгол хийгдээгүй байна.

2. Унаа, хоолны хөнгөлөлт (2100103)-ийн зардал: Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчдад нөхөх төлбөр олгох журам", Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 1/554 тоот албан бичгийг үндэслэн захирлын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/12 дугаар тушаалаар багш, ажилчдад нэг өдрийн 5.0 мянган төгрөгөөр тооцож хоолны хөнгөлөлт олгож эхэлсэн байна. Тайлант онд хоолны хөнгөлөлтийн зардалд 143,290.7 мянган төгрөгийг цалин хөлсний төсөвтөө багтаан олгосон байна.

3. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардал: 2025 онд 22 арга хэмжээ зохион байгуулахаар, нийт 31,244.2 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 22 арга хэмжээ зохион байгуулж 31,206.1 мянган төгрөг зарцуулсан байна. Үүнд:

- Багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх зардлаас тус сургуулийн багш нар өөрсдийн мэргэжлийн зөвлөлийн онцлогт тохирсон сургалтууд, мөн "Хүүхдийн эрхийн тухай сургалт", "Төрөлжсөн цахим системийн сургалт", "Анги удирдах урлаг" зэрэг сэдэвт 16 сургалт авч 19,527.6 мянган төгрөг зарцуулсан байна.
- Хичээлээс гадуурх сургалт семинарын зардлаас ахлах дунд ангийн сурагчдын дунд "Эко клуб, багш хүүхдүүдийн хээрийн судалгааны сургалт", "Байгальд ээлтэй хүүхэд" сэдэвт 2 сургалт зохион байгуулж 5,554.6 мянган төгрөг зарцуулсан байна.
- Хүүхэд хамгааллын зардлаас эцэг эх, асран хамгаалагч, сурагч, багш ажилчдад "Хүүхдийн эрхийн тухай", "Амьдралд ойрхон харилцаа", "Анхаарал дутмагшил хэт хөдөлгөөнтэй зан үйлтэй хүүхэдтэй харилцах нь", "Гэр бүлийн харилцаа хандалга" сэдэвт 4 сургалт зохион байгуулж, 6,123.9 мянган төгрөг зарцуулсан байна.

4. Хэвлэл мэдээллийн байгууллагатай ажил, үйлчилгээний гэрээ: Тайлант онд "Цог энтертаймент медиа студи" ХХК-тай англи хэлний пийрсон хөтөлбөрийн талаарх 5 минутын видео контент бүтээх 450.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан ажил гүйцэтгүүлсэн байна.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд нийт 532,254.7 мянган төгрөгийн, хичээл үйлдвэрлэлийн дадлага 55,525.8 мянган төгрөг, үдийн цай хөтөлбөр 412,298.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 64,430.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг шууд гэрээ болон нээлттэй тендер шалгаруулалтаар зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

Хүүхдийн үдийн хоолны хүнсний материалын нийлүүлэгчийг сонгон шалгаруулах 4 багцтай тендер шалгаруулалт зохион байгуулахаар 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдөр tender.gov.mn цахим системд тендерийн баримт бичгийг байршуулж, худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, нийлүүлэгчийг сонгон шалгаруулсан байна. Тайлант онд үдийн цай хөтөлбөрт 350,404.1 мянган төгрөг батлагдаж, 328,380.4 мянган төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвөөс 22,023.7 мянган төгрөгийг хэмнэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Номундалай сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Оюун-Эрдэнэ гүйцэтгэж, үе шатны хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Номундалай сургууль нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 09 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал Ц.Буянтогтох, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч П.Амаржаргал нар зурж ажиллажээ.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсөв 7,961,784.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 79,617.8 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 51,751.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамаарах асуудал байхгүй бөгөөд батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 104 гүйлгээний 8,917,827.8 мянган төгрөгийн санхүүжилтийн мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Шилэн дансны дэлгэрэнгүй мэдээлэл буюу байгууллагын ерөнхий мэдээлэл дэх мэдээлэл, үнэн зөв, бүрэн гүйцэт, бусад мэдээлбэл зохих бүх мэдээллийг хугацаанд нь байршуулж ажилласан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 1,544.0 мянган төгрөгийн 2 зөрчил илэрсэнд 1 акт, 1 албан шаардлага өгсөн ба хэрэгжилтийг хянаж, үнэлсэн.

Хүснэгт 3. Албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	16,544.0	2	16,544.0	100%
Төлбөрийн акт	1	655.4	1	655.4	100%
Нийт дүн	2	1,544.0	2	1,544.0	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллага нь тайлант онд сургалтын үйл ажиллагаанд ашиглаж буй математик /эдүтэн/ хичээлийн программын үйлчилгээний төлбөрт 13,699.6 мянган төгрөг, англи хэлний /pearson/ хичээлийн программын үйлчилгээний төлбөрт 40,496.5 мянган төгрөг, боловсролын нэгдсэн системийн esis.edu.mn/hr/ программын төлбөрт 25,360.0 төгрөгийг тус тус төлж байгаа асуудлыг дээд шатны захирагч анхаарах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,921.4 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрсэнийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Боловсролын ерөнхий газраас үнэ төлбөргүй шилжиж ирсэн 1-5 дугаар ангийн 7,921.4 мянган төгрөгийн сурах бичгийг орлогоор бүртгэж тайлагнаагүй байна. Энэ нь Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 4 дүгээр зүйлийн 4.1.1, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитаар илэрсэн 1 зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

Аудитаар илэрсэн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Зөвлөмж

Тус сургууль нь 2022 онд гүнзгийрүүлсэн сургалт явуулах журам, 2024 онд сонгон, секц, дугуйлан хичээллүүлэх журам боловсруулан мөрдөж байна. Тус журмуудыг БСШУС-ын 2002 оны 333 дугаар тушаалын хавсралт, 2013 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/448 дугаар “Төрөлжсөн болон гүнзгийрүүлсэн сургалтын тухай” тушаал, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/659 дугаар тушаал “Ерөнхий боловсролын сургуульд секц, дугуйлан зохион байгуулах, санхүүжүүлэх аргачлал” зэрэг тушаалуудыг үндэслэсэн байна. Боловсролын сайдын дээрх тушаалууд хүчингүй болсон байна.

Энэ нь УИХ-аас 2023 онд шинэчлэн баталсан Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-т “Төрөлжсөн сургалтын хөтөлбөрт тавих шаардлага болон нэмэлт зардал, сургалт зохион байгуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гүнзгийрүүлсэн сургалт, сонгон секц, дугуйлан хичээллүүлэх журмуудыг дагаж хэрэгжүүлэх шийдвэрийг хүчин төгөлдөр эрх зүйн актад үндэслэн гаргаж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/			
							Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн
Боловсролын ерөнхий газраас үнэ төлбөргүй шилжиж ирсэн 1-5 дугаар ангийн 7,921.4 мянган төгрөгийн сурах бичгийг орлогоор бүртгэж тайлагнаагүй байна.	1	7,921.4	1	7,921.4			1	7,921.4		
Дүн	1	7,921.4	1	7,921.4			1	7,921.4		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тус сургууль нь 2022 онд гүнзгийрүүлсэн сургалт явуулах журам, 2024 онд сонгон, секц, дугуйлан хичээллүүлэх журам боловсруулан мөрдөж байна. Тус журмуудыг БСШУС-ын 2002 оны 333 дугаар тушаалын хавсралт, 2013 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/448 дугаар "Төрөлжсөн болон гүнзгийрүүлсэн сургалтын тухай" тушаал, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/659 дугаар тушаал "Ерөнхий боловсролын сургуульд секц, дугуйлан зохион байгуулах, санхүүжүүлэх аргачлал" зэрэг тушаалуудыг үндэслэсэн байна. Боловсролын сайдын дээрх тушаалууд хүчингүй болсон байна.	1	0					1	0
Дүн	1	0.0	-	-	-	-	1	0

-----oOo-----